



ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 4/03

Баянхутаг сум

Ажлын байрны тодорхойлолтыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/107 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Багшийн ажлын байрны тодорхойлолтыг 1 дүгээр, багшийн туслахын ажлын байрны тодорхойлолтыг 2 дугаар, нярвын ажлын байрны тодорхойлолтыг 3 дугаар, тогоочийн ажлын байрны тодорхойлолтыг 4 дүгээр, гал тогооны бэлтгэгчийн ажлын байрны тодорхойлолтыг 5 дугаар, жижүүрийн ажлын байрны тодорхойлолтыг 6 дугаар, угаагчийн ажлын байрны тодорхойлолтыг 7 дугаар, үйлчлэгчийн ажлын байрны тодорхойлолтыг 8 дугаар хавсралтаар баталсугай.

2. Ажлын байрны тодорхойлолтоо сайтар судлан, заагдсан ажил үүргээ хариуцлагатай, чанартай гүйцэтгэж байхыг нийт багш, ажилтнуудад үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧИЙГ ТҮР ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Т.НАРАНЦЭЦЭГ